

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	31
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	БОДЬ ДААТГАЛ ХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	АГААРЫН ХӨЛГИЙН ИХ БИЕЙН ДААТГАЛ					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Агаарын хөлгийн даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах тухай		2021.03.31		ТУЗ/2107	
6	Цахимаар борлуулах эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм				<input type="checkbox"/> Үгүй	
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Балсан		Баярмагнай			
<b>Мэдээллийн төрлийг сонгоно уу.</b>							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах <input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
<b>Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл</b>							
9	Даатгалын зүйл	Агаарын хөлгийн их бие, хөдөлгүүрийн хамт (нэмэлтээр эд анги, сэлбэг хэрэгсэл)					
	Даатгалын үндсэн эрсдэл	<ol style="list-style-type: none"> <li>Хасалт хэсэгт зааснаас бусад бүх эрсдэлүүд;</li> <li>Нэрлэсэн эрсдэлүүд:           <ul style="list-style-type: none"> <li>Агаарт болон газарт байх үед тохиолдож болох байгалийн бүх төрлийн эрсдэл, /газар хөдлөлт, галт уул дэлбэрэх, аадар бороо, шороон шуурга, үер ус, хөлдөлт, цөмрөлт, овойлт, гулгалт, хад чулууны нуралт, цасан хуйлралт гэх мэт/;</li> <li>Гал түймэр, бүх төрлийн тэсрэлт, дэлбэрэлт;</li> <li>Цахилгаан эрчим хүчний хэлбэлзэл, хэт ачаалал, богино холболт, цахилгаан соронзон орны нөлөөлөл эрсдэлүүд;</li> <li>Усны бүлэг эрсдэл /усанд автах, ус чийгний нөлөөлөл, химийн үйлчлэлд орж исэлдэх, зэвэнд идэгдэх, цанталт, мөстөлт/;</li> <li>Нислэг үйлдэж буй болон газарт байгаа иргэний агаарын хөлгийн агаарт болон газарт тохиолдох бүх төрлийн тэсрэлт, дэлбэрэлт, агаарын хөлөг сураггүй алга болох, техникийн осол, гэмтэл, саатал;</li> <li>Газрын үйлчилгээ болон ангарт засвар үйлчилгээ хийлгэж байх үеийн агаарын хөлөгт учрах аливаа эрсдэл, үүнд агаарын хөлөг газарт зогсож байхад газрын үйлчилгээний эсвэл бусад машин механизм, бусдын агаарын хөлөг шүргэх, мөргөх, ангарт оруулах гаргах үед болон ангарт байрлаж байх үед гадны биетээр гэмтээх гэм мэт;</li> <li>Шувуу, амьтантай мөргөлдөх</li> <li>Агаарт нисч буй нисдэг биет болон unmanned (drone) – ээс үүдэлтэй аливаа эрсдэл гэх мэт</li> </ul> </li> </ol>					

Даатгалын нэмэлт эрсдэл	Агаарын хөлгүүдийн их биед дайны эрсдлийн улмаас учирч болох хохирол гэх мэт харилцагчийн хүсэлт шаардлагын дагуу
Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0.5-4.0%

#### ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛ:

- Дайн, дотоод гадаад үймээн самуун, иргэний дайн, хувьсгал, ажил хаялт, цэргийн хүчний булаан эзлэлт, нийтийн чанартай санаатай үйлдлүүд, улс төрийн шинжтэй үйлдэл, хуйвалдаан, засгийн газрын хүч хэрэглэсэн үйлдэл.
- Цөмийн эрчим хүч, түүнтэй хамааралтай цацраг идэвхт бодисын нөлөө .
- Даатгуулагчийн санаатай үйлдэл, урьдаас бэлдсэн байдал, нөхөн төлбөр авахтай холбогдсон худал мэдээлэл, хуурамч баримт бичиг бүрдүүлснээс үүдэн гарах хохирол;
- Механик эвдрэл, агаарын хөлгийн их бие, эд ангийн ердийн элэгдэл хорогдол, хөлдөлтөөс үүдэн гарах эвдрэл гэмтэл;
- Нисэх зөвшөөрөлгүй нисгэгч агаарын хөлгийг жолоодож явах үед учирсан аливаа хохирол;
- Гэрээнд тусгагдаагүй нэмэлт сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж (үйлдвэрээс суурилуулагдсан үндсэн эд ангийг засаж сэлбэн суурилуулсан зориулалтын сэлбэг хэрэгсэл нь даатгалын зүйл болно);
- Агаарын хөлгийн өмнө нь мэдэгдэж байсан эвдрэл гэмтлийн холбоотой засвар үйлчилгээг цаг тухайд нь хийгээгүйн улмаас даамжран цааш үүсэн гарах эвдрэл гэмтэл, түүнээс учрах хохирол;
- Даатгалын зүйлд буруу сэлбэг материал ашигласан эсвэл буруу суурилуулсан, угсарсан, задалснаас үүдэн гарсан аливаа хохирол;
- Даатгагдсан агаарын хөлгийн зориулалт өөрчлөгдсөн, бусдад барьцаалах, түрээслэх, зээлдэх болон ашиглуулах үед учирсан хохирол;
- Агаарын хөлгийн нисгэгчийн согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн үед хийсэн аливаа үйлдлээс учирсан хохирол;
- Агаарын хөлгийн даац болон түүгээр зорчих зорчигчийн тоог хэтрүүлсний улмаас үүдэн гарах хохирол;
- Даатгалын зүйлийн өмчлөлд өөрчлөлт орсон талаар 30 хоногийн дотор даатгагчид мэдэгдээгүй болон хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр даатгалын нөхөн төлбөрийн баримт материалыг даатгалын тохиолдол болсон өдрөөс хойш хуанлийн 180 хоног дотор хүлээлгэж өгөөгүй бол;
- Даатгуулагчийн өөрийн хүлээх хариуцлагад хамаарах хохирол;
- Даатгалын хураамжийг гэрээгээр тохиролцсон хугацаанд төлөөгүй тохиолдолд үүссэн хохирлыг даатгагч хариуцахгүй.
- Холбогдох хууль тогтоомжинд заасан бусад үндэслэл үүссэн.